

## **ХОВД АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС**

Нийгмийн даатгал нь нэг талаас аж ахуйн нэгж, байгууллага нь ажилтныхаа нийгмийн хамгааллыг хангах нөхцөл болдог, нөгөө талаас даатгуулагч иргэний амьдралынхаа бүхий л үеийн туршид тухайлбал: хөдөлмөрлөх явцдаа болон өвдөх, жирэмслэх, хүүхэд төрүүлэх, осолд орох, ажилгүй болох, өндөр наслах, тахир дутуу болох тохиолдлуудад орлогогүй буюу орлого нь буурсан нөхцөлд нийгмийн баталгааг нь баталгаатайгаар хангадаг.

### **Нийгмийн даатгалын сангууд**

Нийгмийн даатгалд даатгуулж, шимтгэл төлж байгаа даатгуулагч, иргэн бүр нийгмийн даатгалын үйлчилгээг хүртэх эрхтэй.

Нийгмийн даатгалын сангийн орлогын үндсэн эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрт ажиллаж буй даатгуулагчдаас төлж буй нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ.

Иймээс залуу наснаасаа эхлэн ажил хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалд заавал даатгуулан насан туршийн амьдралын баталгаагаа найдвартай хангах нь иргэн бүрийн эрхэм үүрэг юм.

Нийгмийн даатгалын төрөл тус бүр нь дараах мөнгөн хөрөнгийн бие даасан сантай байна.

- Тэтгэвэрийн даатгалын сан
- Тэтгэмжийн даатгалын сан
- Эрүүл мэндийн даатгалын сан
- Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан
- Ажилгүйдлийн даатгалын сан

### **Тэтгэвэрийн даатгалын сан**

Та тэтгэвэрийн даатгалд даатгуулсанаар:

- Өндөр насны тэтгэвэр
- тахир дутуугийн тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрхтэй.

### **ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР**

Даатгуулагч нь нийт 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

Харин 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 55 нас хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно.

Бүрдүүлэх материал:

1. Нийгмийн даатгалын дэвтэр
2. 1995 оноос өмнө ажиллаж байсан бол хөдөлмөрийн дэвтэр
3. Шимтгэл төлж ажилласан сүүлийн 20 жилийн доторхи дараалсан 5 жилийн цалингийн тодорхойлолт
4. Шаардлагатай бол ажилд орсон гарсан тушаал
5. Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авч 6 настай болтол нь өсгөсөн 4 хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар
6. Ажилласан хугацааг сэргээн тогтоосон шүүхийн шийдвэр
7. Хувийн өргөдөл
8. Иргэний үнэмлэхний хуулбар
9. 3\*4 хэмжээтэй цээж зураг 2 хувь
10. Цэргийн батлах

### **Тахир дутуугийн тэтгэвэр**

Тэтгэвэрийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил төлсөн, эсвэл тахир дутуу болохын өмнөх 5 жилийн 3 жилд нь төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар байнга буюу удаан хугацаагаар алдаж тахир дутуу болсон бол тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

Бүрдүүлэх материал:

1. Нийгмийн даатгалын дэвтэр
2. 1995 оноос өмнө ажиллаж байсан бол хөдөлмөрийн дэвтэр
3. Шимтгэл төлж ажилласан сүүлийн 20 жилийн доторхи дараалсан 5 жилийн цалингийн тодорхойлолт
4. Шаардлагатай бол ажилд орсон гарсан тушаал
5. Ажилласан хугацааг сэргээн тогтоосон шүүхийн шийдвэр
6. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын акт
7. Хувийн өргөдөл
8. Иргэний үнэмлэхний хуулбар
9. 3\*4 хэмжээтэй цээж зураг 2 хувь
10. Цэргийн батлах

### **Тэжээгчээ алдсаны тэтгэвэр**

Шимтгэл төлөх хугацааг хангасан тэжээгч ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барвал түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгож авах эрхтэй.

Бүрдүүлэх материал:

1. Нийгмийн даатгалын дэвтэр
2. 1995 оноос өмнө ажиллаж байсан бол хөдөлмөрийн дэвтэр
3. Шимтгэл төлж ажилласан сүүлийн 20 жилийн доторхи дараалсан 5 жилийн цалингийн тодорхойлолт
4. Ажилласан хугацааг сэргээн тогтоосон шүүхийн шийдвэр
5. Цэргийн батлах
6. Хүүхдийн төрсний гэрчилгээ
7. Нас барсаны гэрчилгээ
8. 16-19 хүртэл насны хүүхдийн сургуульд сурч буй тухай сургуулийн тодорхойлолт
9. Хувийн өргөдөл
10. Иргэний үнэмлэхний хуулбар
11. 3\*4 хэмжээтэй цээж зураг 2 хувь

### Тэтгэмжийн даатгалын сан

Та тэтгэмжийн даатгалд даатгуулсанаар :

- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж
- Оршуулгын тэтгэмж авах эрхтэй

### ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖ

Та дараах нехцелд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах боломжтой.

Ердийн өвчнөөр өвчилж, эсвэл ахуйн осолд орж хөдөлмөрийн чадвараа түр алдахаас өмнө 3 сар буюу түүнээс дээш хугацаагаар тэтгэмжийн даатгалын шимтгэлээ төлсөн. Хүүхдээ жирэмсний 7 сар хүртэл хугацаанд тээж дутуу төрүүлсэн, эсвэл үр хөндүүлсэн.

Хүүхдээ жирэмсний 7 сар хүртэл хугацаанд тээж дутуу төрүүлсэн, эсвэл үр хөндүүлсэн.

Шимтгэл төлж ажилласан жил	Тэтгэмж бодох хувь
5 хүртэлх жил	50
5 — 14 жил	55
15 ба түүнээс дээш жил	75

**Бүрдүүлэх материал:**

- Нийгмийн даатгалын дэвтэр
- Эмнэлгийн хуудас

## **ЖИРЭМСНИЙ БОЛОН АМАРЖСАНЫ ТЭТГЭМЖ**

Жирэмсний болон амаржсаны тэтгэмжтэй холбоотой хуулийн тодруулга

### Нэг. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх:

Заавал болон сайн дураар даатгуулагч эх дараах 2 болзлыг хангасан тохиолдолд тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.

- Заавал болон сайн дураар даатгуулагч эх тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд төлсөн, үүнээс сүүлийн 6 сар нь тасралтгүй төлсөн байх,
- Тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөх дээрх хугацааг хангасан даатгуулагч эх 196 хоног тээгээд дутуу төрүүлсэн болон үр хөндүүлсэн, жирэмсэлтийг эмнэлгийн аргаар тасалсан, мөн 196 хоног тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн бол.

Дээр дурдсан эдгээр нөхцөлийг хангаагүй даатгуулагч эхэд жирэмсний, амаржсаны тэтгэмж авах эрх үүсэхгүй гэж ойлгоно.

### Хоёр. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох:

Заавал даатгуулагч эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, орлогын дунджаас 100 хувиар тооцож тэтгэмжийн даатгалын сангаас 4 сарын хугацаанд олгоно.

Харин сайн дурын даатгуулагч эхийн хувьд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, орлогын дунджаас 70 хувиар тооцон мөн 4 сарын хугацаанд тэтгэмжийн даатгалын сангаас олгоно.

**Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг дор дурдсан баримтыг үндэслэн бодно.**

- Эмнэлгийн хуудас
- Нийгмийн даатгалын дэвтэр

Заавал даатгуулагч эх нь эмнэлгийн хуудсыг байгууллагынхаа хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтанд авчирч өгөх бөгөөд уг ажилтан нь тухайн даатгуулагч эхийн шимтгэл төлж ажилласан хугацааг тодорхойлон бичиж удирдах албан тушаалтнаар гарын үсэг зуруулан, баталгаажуулж нягтлан бодогчид өгнө. Нягтлан бодогч тухайн даатгуулагч эхийн жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг нягтлан шалгаж дараах аргачлалын дагуу тэтгэмжийг бодож олгоно.

**Жишээ 1:** Даатгуулагч эх “А” нэгэн хувийн байгууллагад ажилладаг бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийг 4 жил төлж ажилласан, сарын хөдөлмөрийн хөлс

450 000 /Дөрвөн зуун тавин мянган/ төгрөг, 2012 оны 8 дугаар сарын 01-ний өдөр жирэмсний эмнэлгийн хуудсаа эмнэлгээс бичүүлэн авч байгууллагынхаа санхүүд өгсөн гэвэл дараах аргачлалын дагуу жирэмсний тэтгэмжийг бодно.

Байгууллагын нягтлан бодогч нь даатгуулагч эхийн жирэмсний чөлөө авахаас өмнөх шимтгэл төлсөн 12 сар өөрөөр хэлбэл 2011.08.01-ний өдрөөс 2012.07.31-ний өдөр хүртэлх хугацааны цалин хөлс, орлогыг тодорхойлж, уг цалин хөлс, орлогын нийлбэрээс дундаж цалинг гаргана.

*Хүснэгт№1*

Сарын дундаж хөлс, орлого	Сарын ажлын өдрийн дундаж хоног	Нэг өдөрт ногдох хөдөлмөрийн хөлс, орлого	Тэтгэмж бодох хувь	Нэг өдөрт ногдох тэтгэмж /7*8/	Тэтгэмж олгох хоног /ажлын өдөр/	Олговол зохих тэтгэмж /9*10/
5	6	7	8	9	10	11
450 000	21.2*	21 226	100**	21 226	45***	955 188

**Тайлбар:** \* - Жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох сарын ажлын өдрийн дундаж 21.2 хоног. /21.2-ыг зөвхөн жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодоход хэрэглэнэ./

\*\* - Заавал даатгуулагч эхийн тэтгэмжийг 100 хувиар бодно.

\*\*\*- Тэтгэмж олгох ажлын хоногийг жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсан дээрх хуанлийн хоногоос тооцон гаргана.

Харин сайн дурын даатгуулагч эх нь эмнэлгийн хуудас, нийгмийн даатгалын дэвтрээ оршин суугаа аймаг, сум, дүүргийнхээ нийгмийн даатгалын хэлтсийн байцаагчид авчирч өгч шимтгэл төлсөн хугацааг тодорхойлон бичүүлж, тэтгэмжээ бодуулна.

**Жишээ 2:** Сайн дурын даатгуулагч эх “Б” нь нийгмийн даатгалын шимтгэлийг 1 жил тасралтгүй төлсөн бөгөөд сарын дундаж орлого 180 000 /Нэг зуун наян мянган/ төгрөг, 2012 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр жирэмсний эмнэлгийн хуудсаа эмнэлгээс бичүүлэн авсан тохиолдолд тэтгэмжийг бодъё.

*Хүснэгт№2*

Сарын дундаж хөлс, орлого	Сарын ажлын өдрийн дундаж хоног	Нэг өдөрт ногдох хөдөлмөрийн хөлс, орлого	Тэтгэмж бодох хувь	Нэг өдөрт ногдох тэтгэмж /7*8/	Тэтгэмж олгох хоног /ажлын өдөр/	Олговол зохих тэтгэмж /9*10/
5	6	7	8	9	10	11
180 000	21.2*	8 491	70**	5 943	45***	267 452

**Тайлбар: : \* - Жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох сарын ажлын өдрийн дундаж 21.2 хоног. /21.2-ыг зөвхөн жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодоход хэрэглэнэ./**

**\*\* - Сайн дурын даатгуулагч эхийн тэтгэмжийг 70 хувиар бодно.**

**\*\*\*- Тэтгэмж олгох ажлын хоногийг жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсан дээрх хуанлийн хоногоос тооцон гаргана.**

Даатгуулагч эх амаржсаны дараа 30 хоногийн дотор амаржсаны эмнэлгийн хуудсаа эмнэлгийн байгууллагаар бичүүлэн заавал даатгуулагч эх бол байгууллагын санхүүдээ, сайн дураар даатгуулагч эх бол харьяалах аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст өгнө. Амаржсаны тэтгэмжийг бодоход жирэмсний тэтгэмж бодсон дундаж хөдөлмөрийн хөлс, орлогоос дахин бодно.

**Жишээ 3:** Жишээ 1 дээр авсан даатгуулагч эх “А” 2012 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр төрсөн гэвэл амаржсаны тэтгэмжийг хэрхэн бодох талаар жишээ авья.

Даатгуулагч эхийн амаржсаны эмнэлгийн хуудсыг 2012 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн бичнэ. Даатгуулагч эхийн амаржсаны тэтгэмжийг бодоход жирэмсний тэтгэмж бодсон дундаж цалингаас бодох тул дахин дундаж цалин бодох шаардлагагүй. Амаржсаны эмнэлгийн хуудсан дээрх 2012.09.15-ны өдрөөс 2012.11.15-ны өдөр хүртэлх хуанлийн хоногоос ажлын өдрийг тоолно.  
*Хүснэгт№3*

Сарын дундаж хөлс, орлого	Сарын ажлын өдрийн дундаж хоног	Нэг өдөрт ногдох хөдөлмөрийн хөлс, орлого	Тэтгэмж бодох хувь	Нэг өдөрт ногдох тэтгэмж /7*8/	Тэтгэмж олгох хоног /ажлын өдөр/	Олговол зохих тэтгэмж /9*10/
5	6	7	8	9	10	11
450 000	21.2	21 226	100*	21 226	44**	933 944

**Тайлбар:**

**\* - Тэтгэмж авагч заавал даатгуулагч тул 100 хувиар бодно.**

**\*\* - Тэтгэмж олгох ажлын хоногийг жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсан дээрх хуанлийн хоногоос тооцон гаргана.**

Гурав. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авч байх хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөлт:

Заавал даатгуулагч эхийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан 4 сарын хугацааны шимтгэлийг ажил олгогч нь тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих дор дурдсан хувиар тооцож сар бүр төлнө.

*Хүснэгт№4*

№	Даатгалын төрөл	Шимтгэл төлөх		
		Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /төг/	Ажил олгогчийн төлбөл зохих хувь	Сард төлөх шимтгэлийн дүн
1	Тэтгэврийн даатгал	140400	7.0	9828
2	Тэтгэмжийн даатгал		0.5	702
3	Эрүүл мэндийн даатгал		2.0	2808
4	Ажилгүйдлийн даатгал		0.5	702
5	ҮОМШӨ-ний даатгал		1.0, 2.0, 3.0	1404, 2808, 4212
	<b>Бүгд</b>	<b>140400</b>	<b>11, 12, 13</b>	<b>15444, 16848, 18252</b>

**Тайлбар: ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагаас хамааралтайгаар ажил олгогчоос 1-3 хувиар ялгавартайгаар тогтоохоор заасан.**

### **ОРШУУЛГЫН ТЭТГЭМЖ**

Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ 36 сараас доошгүй хугацаагаар төлсөн даатгуулагч ердийн евчин, ахуйн ослын улмаас нас барсан тохиолдолд оршуулгын тэтгэмж 300000 төгрөгийг олгоно. Харин даатгуулагч уйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан овчний улмаас нас барсан бол оршуулгын тэтгэмжийг шимтгэл төлсөн хугацааг харгалзахгүйгээр олгоно.

### **Бүрдүүлэх материал:**

- Нас барсан даатгуулагчийн хөдөлмөрийн дэвтэр
- Нас барсан даатгуулагчийн даатгалын дэвтэр
- Нас барсны гэрчилгээ
- Өргөдөл

**Жич: Дэлгэрэнгүй мэдээллийг [WWW.NDAATGAL.MN](http://WWW.NDAATGAL.MN) цахим хуудас болон лавлах утас:1289**